

АЗИЙН ШИНЭ “БАР” ВЬЕТНАМ

*Б.Гантуяа**

БНСВУ-ын Коммунист нам, Засгийн газар хоорондын нягт уялдаа холбоотой, төвлөрсөн зохион байгуулалт бүхий удирдлагын тогтолцоон дор 1980-аад оны дунд үеэс эхлэн зах зээл эдийн засгийн шинэ тогтолцоонд шилжин орсноос хойш экспортын баримжаатай орчин үеийн, шинээр аж үйлдвэржсэн орны суурь үндсийг хөгжүүлэх бодлогыг тууштай хэрэгжүүлсний үр дүнд өдгөө Вьетнам улс эдийн засгийн шинэчлэлийг эрчимтэй хийж, дэлхий нийтэд нээлттэй болж, эдийн засгаа либеральчилж, зах зээлийн харилцаанд эргэлт буцалтгүй шилжиж, олон улсын тавцан дээр нэр хүнд, байр суурь нь жилээс жилд бэхжиж явна. Вьетнам улс АСЕАН-ны гишүүн 10 орны нэг бөгөөд эдийн засгийн эрчимтэй хөгжлийн үр дүнд бий болсон эдийн засгийн өндөр чадавхи бүхий Азийн “Шинэ буюу Зулзаган Бар” хэмээгдэх болжээ. Вьетнам улс хэрхэн Азийн “Зулзаган Бар” болсныг бяцхан түүхээс дор сийрүүллээ.

Дотоодын нийт бүтээгдэхүүний түргэн өсөлт

Вьетнам улсад дайны дараахи сэргээн босголтын үйл явц 1970-1980-аад оны эцэс хүртэл явагдсан боловч эдийн засаг нь бүхэлдээ сүйрсэн, хүн амын өргөн хэрэгцээний бараа, хүнс тэжээлээр дутмаг, картын системтэй байв. 1986 оноос эхлэн Вьетнамын Коммунист Нам улс орны эдийн засгийг өөд татах өөрчлөлт шинэчлэлийн бодлого хэрэгжүүлж, 1984-1985 онд 500% хүрч байсан инфляцын хэмжээ 90-ээд оны дундуур 5-6% болтол буурч, ДНБ-ний хэмжээ 1991-1994 онуудад 8,3%-иар өсч, 1995 онд ДНБ-ний хэмжээ 9.5% болж, Вьетнам улс нийгэм эдийн засгийн хямралаас бүрэн гарсан гэж үздэг. Хэдийгээр 1997-1998 оны сүүлээр тохиосон Азийн санхүүгийн хямралын улмаас 1997 онд 8,2% байсан эдийн засгийн өсөлт 1999 онд 4.7% болтол буурсан боловч Вьетнам улс эдийн засгийн уналтанд гүнзгий ороогүй юм. 2004 онд ДНБ-ний хэмжээ 8,4% болсон нь 1997 оноос хойш эдийн засгийн өсөлтийн хамгийн өндөр үзүүлэлт болжээ. 2003 онд Вьетнам улс эдийн засгийн өрсөлдөх чадварын шалгуур үзүүлэлтийн байдлаар дэлхийд 143, Ази тивд 36, ЗӨА-ийн бүс нутагт 7 дугаарт жагсаж байна. Вьетнамын орон нутагт өнөөдөр нийт 135 үйлдвэрлэлийн болон экспортын нээлттэй бүсүүд үйл ажиллагаагаа явуулж байна.


* Б.Гантуяа - магистр



Эх сурвалж: Вьетнам Улсын Статистикийн Төв Газар (2007)

Дээрх графикаас Вьетнам орны эдийн засаг, нийгэм өнгөрсөн арав гаруй жил тогтвортой, хурдацтай хөгжсөөр ирсэнийг харуулж байна. 2000 онд Вьетнам улсын ДНБ 6.7% (1990 оныхоос 2 дахин илүү), 2001 онд 6.8%, 2003 онд 7.0%, 2004 онд 7.7%, 2005 онд 8.44%, 2006 онд 7.24%, 2007 онд 8.45% тус тус өсчээ. НҮБ-ын Ази, Номхон далайн бүс нутгийн нийгэм эдийн засгийн хорооноос (ESCAP) хийгдсэн судалгаагаар, 2007 онд дотоодын эрэлт өсч, экспортын хэмжээ болон гадаадын шууд хөрөнгө оруулалт нэмэгдсэнээр эдийн засгийн өсөлт нь сүүлийн арваад жилийн хамгийн өндөр үзүүлэлттэй болж, Вьетнам улс Ази тивд БНХАУ-ын дараа 2-р байранд, АСЕАН-ны бүс нутагт 1-рт орсон.

Вьетнам улсын ирээдүйн хөгжил хэрхэн өрнөх нь олон хүчин зүйлээс шалтгаална. Вьетнам улсын хүн ам 85 саяд хүрч, дэлхийд хүн амын тоогоор 13-р байранд орж байна. Ажил эрхлэх ихэнхи хүмүүс нь 25-35 насны, өндөр боловсролтой залуучууд байгаа нь эдийн засгийн хөгжилд сайнаар нөлөөлж байна.



ХАА-н бүтээгдэхүүн: цагаан будаа, каучук, кофе, цай, хар чинжүү, буурцаг, кешу самар, сахарны нишинг, гадил жимс, тэжээвэр шувуу, загас, далайн бүтээгдэхүүн.

Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн: хүнс боловсруулалт, бэлэн хувцас, гутал, машин үйлдвэрлэл, уул уурхай, нүүрс, ган цувимал, цемент, химийн бордоо, шил, дугуйн бүрээс, газрын тос, цаас, цаасан бүтээгдэхүүн.

Хөдөө аж ахуй, хөдөө тосгоны үйлдвэрлэлийн бүтцийн шинэчлэл

Вьетнамын засгийн газраас явуулж буй өөрчлөлт, шинэчлэлийн чиг бодлогын үр дүнд, хөдөө аж ахуй, хөдөө тосгоны үйлдвэрлэлийн бүтцэд шинэчлэл хийх, өөрчлөлт оруулан хурдацтай хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих, шинжлэх ухаан техникийн хамгийн сүүлийн ололт амжилтуудыг үйлдвэрлэлд нэвтрүүлэх, ХАА-н бүтээгдэхүүний сортыг шинэчлэх, чанартай бүтээгдэхүүн үйлдвэрлэж дэлхийн зах зээлд өрсөлдөх чадвартай болгох зэрэг арга хэмжээнүүд хийгдэж байна. Вьетнам улс цагаан будаа, түүхий эд, нефть, каучук, кофе, далайн гаралтай хагас боловсруулсан бүтээгдэхүүн, төрөл бүрийн жимс зэрэг хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг дэлхийн зах зээлд их хэмжээгээр нийлүүлэх болсноор Ази-Номхон далайн бүс нутаг дахь ХАА-н гаралтай экспортын хувьд хүчтэй өрсөлдөгч орны нэг болжээ. Өнөөдөр Вьетнам улс цагаан будааг дэлхийн 70 гаруй улс оронд нийлүүлж, цагаан будааны экспортоор дэлхийд 3-р байр, цагаан будааны чанараар 5-р байр, Зүүн Өмнөд Азийн бүс нутагт цагаан будааны экспортоор тэргүүлж, чанарын хувьд 2-р байранд ороод байна. 2006 онд Вьетнам улсын кофены экспорт анх удаагаа цагаан будааны экспортыг давж, дэлхийн кофе экспортлогч улс орнуудыг гүйцэж, Бразилийн дараа 2-р байранд орсон байна. 2007 онд Вьетнам улс кешу самарын экспортоор дэлхийд 1-р байрыг эзэлсэн. Вьетнамын хар чинжүүний экспорт хоёр дахин нэмэгдэж (2006 онд 1540 тонн байсан бол 2007 онд 3760 тонн болж өссөн), хар чинжүүний дэлхийн зах зээлийн тэн хагасыг гартаа авч, үнийн өөрчлөлтөнд нөлөөлөх боломжтой болсон ажээ.

Нэг хүнд оногдох дотодын нийт бүтээгдэхүүн

Дэлхийн улс орны хөгжлийн түвшинг тодорхойлдог гол хэмжигдэхүүн нь нэг хүнд ногдох ДНБ-ний хэмжээ юм. “Буурай хөгжилтэй улс орон”-ны тооноос гарах гол шалгуур нь нэг хүнд жилд оногдох ДНБ-ний дундаж үзүүлэлт 1035 ам.доллартай тэнцэх ёстой байдаг. 2002 оны байдлаар UNCTAD-ын тодорхойлсон дээрхи шалгуур үзүүлэлтийг дэлхийн нэн буурай хөгжилтэй гэж тооцогдох 49 улс орны 10 нь бүрэн хангаад байна. 2002 онд НҮБ-ын Худалдаа Хөгжлийн Хорооноос (UNCTAD) Вьетнам улс дэлхийн “буурай хөгжилтэй улс

орон”-ны тооноос нэгэнт гарсан болохыг албан ёсоор мэдэгдсэн. Вьетнам улсад хүн ам тутамд ногдох ДНБ үзүүлэлт 1991 онд 181 ам.доллар байсан бол 2003 онд 483 ам.доллар, 2006 онд 722 ам.доллар, 2007 онд 835 ам.доллар байгаа нь UNCTAD-ын тодорхойлсон шалгуурт хүрээгүй боловч хүн амын амжиргааны чанарын түвшин, эдийн засгийн тогтвортой байдал зэрэг бусад шалгуураар Вьетнам улсыг харьцангуй өндөр үзүүлэлттэй улс орон гэж дүгнэв. Энэ үзүүлэлтээр Вьетнам улс ЗӨА-ийн бүс нутагт 8-рт /11/, Ази тивд 39-д/52/, дэлхийн улс орны 142-р/200/ байранд байна. Вьетнамын Засгийн газар 2010 онд дээрхи үзүүлэлтийг 1050-1100 ам.доллар болгох зорилт тавин ажиллаж байна.

Ядуурлыг бууруулах зорилт

Вьетнам улс 1992 оноос эхэлсэн шилжилтийн явцад ядуурлыг эрчимтэй бууруулах зорилго тавьсан билээ. Уг зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд Вьетнам улс 1991-2000 онуудад жил бүр 1.2–1.3 сая ажлын байр шинээр бий болгон, ядуу өрх айлын тоог 30%-аас 11% болтол бууруулсан. 1993 онд ядуу хүний тоо 58%-иар, 1997 онд 37%-аар, 2002 онд 29%-иар буурсан, ойролцоогоор 25 сая хүнийг ядуурлаас гаргасан нь ядууралтай эрчимтэй тэмцэж, ядуу хүмүүсийн тоо 5 жилийн дотор 21%-аар буурсан зэрэг үзүүлэлтээр дэлхий нийтэд өндрөөр үнэлэгдсэн юм. 1999 онд Вьетнам улс хүн амын бодлогыг амжилттай хэрэгжүүлсэн тул НҮБ-ийн өндөр шагнал хүртжээ. 2002 онд Дэлхийн Банк “ийм богино хугацаанд ядуурлыг бууруулахад өндөр амжилт гаргаж чадсан ямар ч улс орон байгаагүй” гэж онцлон тэмдэглэсэн байдаг. 2004 онд ядуурлын түвшин 70%-аас 27% болтол буурч, 2007 онд 1.7 сая ажлын байрыг шинээр бий болгожээ.

2003-2004 оны хүн амын сарын дундаж орлого 484000 донг болж, 2001-2002 оныхоос 36%-иар өсчээ. 2002-2004 онд хүн амын сарын дундаж орлого 16.6% өссөн нь 1999-2001 оны 6%, 1996-1999 оны 8.8%-ийн жилийн дундаж орлогоос өндөр байна. Өнөөдөр цалингийн доод хэмжээ сард дунджаар 290000 донг (16 ам.доллар/сард) байна, 2007 онд 340000 донг болгох төлөвлөсөн байна.

Хүн ардын эрүүл мэндийн салбарт мэдэгдэхүйц ахиц гарчээ. Сүүлийн 10 жилд хүн амын өсөлт 2.3%-иас 1.4% хувиар буурч, төрөлтийн жилийн дундаж үзүүлэлт 0.78%-аар багасч (26/1000), хүн амын дундаж наслалт 65.2 жил байснаа 68.3 болж нэмэгдлээ. 1995 онд 5 наснаас доош хүүхдийн сульдаа 38% байсан бол 2000 он гэхэд 33-34%, 2004 он гэхэд 26%-иар буурчээ. Мөн 5 наснаас доош хүүхдийн эндэгдэл 81%-аас 42% (0,04%) болж буурсан (36/1000). Бичиг үсэг тайлагдсан байдал 93.7% байна.

Вьетнам улс Дэлхийн Худалдааны Байгууллагын гишүүн

2006 оны 12-р сард Вьетнам улс ДХБ-ын 150 дахь гишүүн болсноор өөрийн орны эдийн засаг, худалдааны хамтын ажиллагааг хөгжүүлэх таатай нөхцөл бүрдэж, зах зээлээ тэлэх, эдийн засгийн хөгжлийг улам түргэтгэх, дэлхий нийтийн зах зээл, дэлхий дахины өрсөлдөөний сүрлэг хүчинд эдийн засгаа нээж, эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэх, улсын эдийн засгийн шинэчлэлийг түргэтгэх, эрх зүйн хүчтэй улс орон байгуулах, дотоодын зах зээлээ өргөтгөх, худалдааг улам идэвхтэй хөгжүүлэх, ГШХО-ыг эрчимтэй татах, татварын зарим нэгэн хөнгөлөлт эдлэх, дэвшилт технологи нэвтрүүлэн үйлдвэрлэл технологийг түргэн урагшлуулах зэрэг боломжууд нээгдэж байна. Вьетнам улсын бараа бүтээгдэхүүн ДХБ-ын гишүүн орнуудын зах зээл дээр үндэсний нэн тааламжтай нөхцөл эдлэх болсон нь үйлдвэрлэлээ улам бүр эрчимжүүлэх, харьцангуй давуу тал болох хямд ажлын хүчийг бүрэн ашиглах боломжтой болж, Вьетнам улсын дэлхийн экспортод эзлэх хувь улам нэмэгдсээр байгаа юм.


Өдгөө Вьетнам улс “дэлхийн олон улс оронтой найрсаг харилцаа хөгжүүлэх” идэвхтэй гадаад бодлого баримталж, дэлхийн 167 улс оронтой дипломат, 221 улс болон бүс нутагтай худалдааны харилцаа тогтоожээ. Вьетнам улс дэлхийн 219 улсад бараа экспортолж, 151 улсаас импорт оруулж байна.

Экспорт

2006 онд Вьетнам улс 39.6 тэрбум ам.долларын бараа экспортоор гаргаж, үүний 20% АНУ-д, 18% Европын Холбооны улс орнуудад, 13% Япон улсад гаргажээ. Экспортын гол 9 бүтээгдэхүүний (газрын тос, хувцас, арьсан гутал, далайн бүтээгдэхүүн, модон эдлэл, цахилгаан бараа, цагаан будаа, кофе, каучук) гаралт 1 тэрбум ам.доллараас давсан. 2007 онд экспортын хэмжээ 48.3 тэрбум ам.долларт хүрсэн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 20.5%-иар өссөн байна.

Импорт

2006 онд импортоор 44.4 тэрбум ам.долларын бараа оруулсан. Импортоор нийлүүлэгдсэн барааны ихэнхи хувийг цаас, химийн бодис, машин үйлдвэрлэлийн бүтээгдэхүүн эзэлж байна. Импортын гол бүтээгдэхүүн ган цувимал, эрдэс бордоо, шатахуун тосолгооны материал, цэргийн болон ахуйн машин үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнүүд (авто агаарын тээврийн хэрэгсэл, трактор, суурь машин, уул уурхайн олборлолтын тоног төхөөрөмж) орж байна. 2007 онд импортоор 60.7 тэрбум ам.долларын бараа оруулсан нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 31 хувиар өссөн байна.



Эх сурвалж: Вьетнам Улсын Статистикийн Төв Газар (2007)

Гадаадын шууд хөрөнгө оруулалт

1987 оны 12-р сарын 31-нд батлагдсан Вьетнам улсын Гадаадын шууд хөрөнгө оруулалтын хууль 1988 оны 1 дүгээр сарын 1 өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болжээ.

Вьетнамын Засгийн газар улс орны макро эдийн засгийн тогтвортой байдал болон салбарын хөгжилд нэг чухал хүчин зүйлс болох хөрөнгө оруулалтын оновчтой бодлого явуулж, эдийн засгийн хөгжлийн бодлого, үйлдвэрлэлийн өсөлтөд хүргэх хөрөнгө оруулалтын үндсэн стратеги үзэл баримтлалыг зөв боловсруулж, аж үйлдвэрийн салбаруудын тэргүүлэх дарааллыг тодорхойлж, нэн тэргүүнд экспортын тэргүүлэх салбаруудын хөгжлийг дэмжих хөрөнгийг оновчтой ашигласан, хөрөнгийн ашиглалтанд улсаас хатуу хяналт тавьсан зэрэг арга хэмжээнүүд Вьетнам улсыг хөрөнгө оруулалтын найдвартай, аюулгүй орчин бүхий улс орны тоонд оруулахад чухал үүрэг гүйцэтгэсэн. Улс төр, зах зээлийн тогтвортой байдал, хууль зүйн таатай орчин, валютын системд бүрэн шилжсэн, хэрэглээний үнийн индексийн өсөлт бага, эдийн засгийн нээлттэй бүсүүд шинээр бий болсон зэрэг хүчин зүйлүүдээрээ 2001 онд Вьетнам улс гадаадын хөрөнгө оруулалтын найдвартай, аюулгүй орчин бүхий дэлхийн 200-гаад улс орны жагсаалтанд 13 дугаар байранд орж байв.

1989-1995 онуудад ГШХО голчлон аж үйлдвэрийн бус салбарт (зочид буудал, үйлчилгээ) төвлөрч байсан бол 1997 оноос эхлэн өнөөг хүртэл ГШХО газрын тос, байгалийн хийн хайгуулын ажил, олборлолт, барилга байгууламж, барилгын материалын үйлдвэрлэл, машин угсралт, машины сэлбэг тоног төхөөрөмж, компьютер болон түүний эд анги, эмнэлгийн багаж хэрэгсэл, цахилгаан бараа зэрэг аж үйлдвэрийн салбарт төвлөрч байна.



Эх сурвалж: Вьетнам Улсын Статистикийн Төв Газар (2007)

Өнгөрсөн 20 жилд Вьетнам улс дэлхийн 82 гаруй улс орон, бүс нутгаас хуримтлагдсан дүнгээр 98 орчим тэрбум ам.долларын ГШХО хийгдэж, гадаадын шууд хөрөнгө оруулалттай 9500 гаруй төсөлд зөвшөөрөл олгожээ.

2003 онд, Вьетнам улс дэлхийн 70 гаруй улс орон, бүс нутгийн томоохон компаний 3.1 тэрбум ам.долларын шууд хөрөнгө оруулалтыг татаж чадсан нь 2002 оныхоос 26.3%-иар нэмэгдсэн байна. 2006 онд Вьетнам улсын ГШХО 10.2 тэрбум ам.доллар байсан бол 2007 онд 20.3 тэрбум ам.долларт хүрч, өнгөрсөн оныхоос 69.3%-иар өсч, улсын жилийн төлөвлөгөөг 56.3%-иар давуулан биелүүлсэн нь сүүлийн 20 жилд оруулсан ГШХО-ын 20 хувийг эзэлжээ. БНСВУ-ын Хөрөнгө оруулалт-төлөвлөлтийн Яамны Хөрөнгө оруулалтын Хэлтсийн мэдээлснээр, 2007 оны эхний 10 сарын байдлаар, хөрөнгө оруулалтын 1144 төслийг шинээр бүртгэжээ. Хөрөнгө оруулагчдын жагсаалтыг Өмнөд Солонгос 20.2% (2.44 тэрбум ам.долл), Тайвань 29.3%, АНУ 26.9%, Их Британийн Виржиний арлууд 17.8% (1.73 тэрбум ам.долл), Сингапур (1.37 тэрбум ам.долл) зэрэг улс орнууд тэргүүлж байна.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. “Вьетнам 2002-2003”, Ханой, х-80 , (орос хэл дээр)
2. “Вьетнам 2002-2003”, Ханой, х-80
3. “Вьетнам Улсын Эдийн засгийн мэдээ” сониноос жил бүр эрхлэн гаргадаг эдийн засгийн сэтгүүл (2002-2004), (2004-2005),
4. Вьетнам Улсын Статистикийн Ерөнхий Газрын сайтын мэдээлэл: www.gso.gov.vn
5. “Вьетнам 2002-2003”, Ханой, х-80 , (орос хэл дээр)
6. “Вьетнам 2002-2003”, Ханой, х-80 , (орос хэл дээр)
7. ВКН-ын 1X дугээр Их Хурлын ВКН-ын Гүйцэтгэх Төв Хорооны V111 дугаар Чуулганы баримт бичиг, “Эдийн засаг-нийгмийн хөгжлийн 5 жилийн төлөвлөгөөний үндсэн зорилт, чиг бодлого 2001-2005 он”
8. World Investment report 2005, 2006 UNCTAD, эмхэтгэлүүд
9. <http://www.tcvn.gov.vn/>
10. <http://www.vietnamnet.vn/>